



## Үнэт зүйлс

**Аюулгүй ажиллагаа** – Хүний амь нас, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавина Бид үндсэн болон гэрээт ажилтнуудын аюулгүй ажиллагааг ямагт нэн тэргүүнд хангаж ажилладаг.

**Бизнесийн Ёс зүй** – Ил тод, итгэл даасан, шударга байдлыг эрхэмлэнэ. Бизнесийн ёс зүй ба хариуцлага бол “ББА МАНДАХ” ХХК-ийн суурь үнэт зүйлс бөгөөд хамтрагч нарын өмнө хүлээсэн итгэлийг дааж, үйл ажиллагаа явуулах нь манай бизнесийн үндэс юм.



**Хөгжил дэвшил** – Үргэлж шинийг эрэлхийлж, шинэ санаа, шилдэг технологийг нэвтрүүлэн ажиллана. Бид үргэлж суралцаж, үйл ажиллагаагаа улам сайжруулж амжилт өөд тэмүүлнэ.

**Хүндэтгэл** – Бид хамтран ажиллагсдынхаа үндэс угсаа, үзэл бодол, мэдлэг чадвар, соёлын ялгааг хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ. Бие биетэйгээ шударга, хүндэтгэлтэй харилцаж, хүн нэг бүрийн хүчин зүтгэлийг шударгаар үнэлж урамшуулна.



## Үйлчилгээ

### Катеринг

“ББА МАНДАХ” ХХК нь уул уурхайн томоохон компаниудын хүнсний болоод ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг тээвэрлэлтийн хамтаар чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг бөгөөд үүнийгээ бид, харилцагч компаниудын үндсэн үйл ажиллагааг тасралтгүй байх нөхцөл байдлыг хангаж байна хэмээн ойлгодог юм.

Бид 2011 оноос эхлэн эрүүл ахуйн чанарын стандартад нийцүүлэн явуулын болон суурин кемпийн кетринг үйлчилгээг хийж эхлэсэн бөгөөд “Болд Төмөр Ерөө гол” ХХК, Петро Матад ХХК, Логинтик Монголиа ХХК зэрэг компаниудад зориулан явуулын кемпийн үйлчилгээг, мөн суурин кемпийн үйл ажиллагааг хариуцан уурхайчдын тав тухтай, аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

- Явуулын кемпийн кетринг үйлчилгээ
- Уул уурхайн өрмийн болон хайгуулын ангийн явуулын кемпийн үйлчилгээний үйл ажиллагаа
- Суурин кемпийн кетринг үйлчилгээ
- Уурхайн ажилчдын хотхоны нийтийн хоолны болон угаалга, цэвэрлэгээний болон бусад үйлчилгээ

### Барилгын ажил, угсралт, засвар үйлчилгээ

- Дулааны шугам гол сүлжээ, түүний угсралт холболтын ажил
- Усан хангамж, сантехникийн шугам хоолойн холболт угсралт, засвар үйлчилгээ
- Иргэний болон үйлдвэрлэл үйлчилгээний барилга орон сууцны Интерьер, Экстерьер

### Эрчим хүч холбоо дохиололын үйлчилгээ

- Цахилгаан дамжуулах гол шугам, түүний холболт, засвар үйлчилгээ
- Эрчим хүчний эх үүсвэрийн технологийн зураг төсөл
- Холбоо дохиололын холбот суурилуулалт, засвар үйлчилгээ



## Бидний тухай

ББА МАНДАХ ХХК нь 2010 оноос гадаад, дотоод худалдаа, катеринг үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Өдгөө Монгол улсад хэрэгжиж буй Уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд, дотоодын компаниудад олон улсын үйлдвэрлэгч компаниудын бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж байна.

Бид Дэлхийн тэргүүлэгч 10 гаруй үйлдвэрлэгчдийн Монгол улс дахь албан ёсны борлуулагчаар ажиллаж байна.

## Бизнесийн Философи

### Эрхэм зорилго

Бид аюулгүй ажиллагаа, нийгмийн хариуцлага, ёс зүй, чанарыг эрхэмлэн дээдэлж, харилцагч түншүүдтэйгээ урт хугацаанд тогтвортой харилцаж, “Дэлхийн чанарыг Монголд” гэсэн уриаг эрхэм зорилгоо болгон ажиллана.

### Алсын хараа

Бид үргэлж шинийг эрэлхийлж, шинэ санаа, шилдэг технологийг импортлон, бүх түвшний харилцагчдынхаа үнэ цэнэтэй нийлүүлэгч нь байж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацаанд хувь нэмэр оруулна.



### УУЛ УУРХАЙ

Бүх төрлийн уул уурхайн зориулалттай машин, механизм, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгслүүдийг дэлхийн хаанаас ч бид импортлоно.



### БАРИЛГА

Барилгын салбарт шаардлагатай бүхий л түүхий эд материал, багаж хэрэгслүүдийг өргөн сонголттойгоор нийлүүлнэ.



### ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Хөдөлгөөнт болон хөдөлгөөнт бус тоног төхөөрөмжийн худалдаа, тэдгээрийн угсралт суурилуулалтыг чанартай, түргэн шуурхай гүйцэтгэнэ.



### КАТЕРИНГ

Эрүүл ахуйн чанарын стандартад нийцүүлэн явуулын болон суурин кемпийн кетринг үйлчилгээг үзүүлнэ.



### ЭРЧИМ ХҮЧ

Эрчим хүчний салбарт ашиглагдах тоног төхөөрөмж, багаж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, цахилгаан дамжуулах утас, кабелуудыг өргөн сонголттойгоор импортлон борлуулж байна.



### ГЭРЭЛТҮҮЛЭГ

Олон улсын чанар стандартын шаардлага хангасан гэрэл, гэрэлтүүлгийн төхөөрөмж үйлдвэрлэгч компаниудын Монгол улс дахь албан ёсны борлуулагчаар ажиллаж байна.



# БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

✉ [sales@bbamandakh.mn](mailto:sales@bbamandakh.mn); [www.bbamandakh.mn](http://www.bbamandakh.mn)

☎ +976 77475789, +976 88025789, +976 86115789, +976 86105789

📍 Монгол Улс, Улаанбаатар хот - 13311,  
Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүннүгийн  
гудамж 403 байр 45 тоот

